

“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК



СОЛОНГО 1,2 ТӨСЛИЙН НЭГЖИЙН  
АЖИЛЧДЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН  
ХУВЦАС, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ТЕНДЕР  
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Солонго 1,2 төслийн нэгжийн  
ажилчдын хөдөлмөр хамгааллын  
хувцас, багаж хэрэгсэл

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

ТОСКТӨХХК/20250102095

Улаанбаатар  
2025 он

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) .....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж .....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч .....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ .....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл .....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах .....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл .....	3
11. Тендерийн иж бүрдэл.....	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг .....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага .....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт .....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт .....	8
20. Тендерийн валют .....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа .....	9
22. Тендерийн баталгаа .....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх .....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	10
25. Тендерийн талаар тодруулга авах .....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх .....	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	11

30.	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт .....	11
31.	Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	11
32.	Тендерийг эрэмбэлэх .....	11
33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах .....	11
34.	Мэдэгдэл хүргүүлэх .....	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12

# I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Тендерийн цар хүрээ</b>                        | <b>1.1.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.  |
| <b>2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг</b> | <b>1.2.</b> Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.   |
| <b>3. Худалдан авах ажиллагааны тогтоомж</b>         | <b>1.3.</b> Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.  |
| <b>4. Худалдан авах ажиллагааны систем</b>           | <b>1.4.</b> Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.   |
| <b>5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс анgid байх</b> | <b>2.1.</b> Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өргтийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.  |
|  | <b>3.1.</b> Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.   |
|  | <b>4.1.</b> Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ( <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> ) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.   |
|  | <b>5.1.</b> Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч**      **этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

## **Б.АГУУЛГА**

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**
- 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
- I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
  - II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
  - III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
  - IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
  - V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
  - VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.
- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.
- B. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зэрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
  - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
  - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
  - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
  - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
  - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
  - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
  - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
  - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
  - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- |   |               |  |
|---|---------------|--|
| <b>14. Тендерийн маягтууд</b>   | <b>жишиг</b>  | 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.<br>13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.  |
| <b>15. Хувилбарт санал</b>  |               | 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.  |
| <b>16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг</b>  |               | 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.<br>16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.<br>16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.<br>16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:<br>16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;<br>16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;<br>16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.<br>16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална. |
| <b>17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг баримт бичиг</b> | <b>нотлох</b> | 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн <b>Error! Reference source not found.</b> -ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.<br>17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.   |

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээллэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсэн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 24. Тендерийн баталгаа**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маят 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.
- Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**
- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

<b>31. Давуу эрх олгох</b>		31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
<b>32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт</b>		31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцгчийн ирүүлсэн тендэрээс татгалзах үндэслэл болохгүй.
<b>33. Тендерийн харьцуулах тодорхойлох</b>	үнийг	31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
<b>34. Тендерийг эрэмбэлэх</b>		32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
<b>35. Оролцгчийн чадавхыг магадлах</b>	дахин	33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үндсэн журмыг баримтална. 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцгчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцгчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.
<b>Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>		
<b>36. Шийдвэр хүргүүлэх</b>		36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-НЫ ХОЛБОГОХ ЗААЛТ	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: <b>“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ “ТӨХХК</b>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: <b>Хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгсэл</b>
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: <b>ТОСКТӨХХК/20250102095</b>
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багц № 1: Хөдөлмөр хамгааллын хувцас</b> <b>Багц № 2: Багаж хэрэгсэл</b>
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: <b>Дотоодын багц № 1: Хөдөлмөр хамгааллын хувцас</b> Нийлүүлэх бараа нь Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөн батлагдсан <b>“Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”</b> -д орсон бараа байх бөгөөд Стандарт, хэмжил зүйн газраас олгосон тохирлын гэрчилгээг ирүүлнэ. /Тус гэрчилгээ нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна/.
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b>
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Өөрийн хөрөнгө</b>
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: <b>104,500,000.00 /Нэг зуун дөрвөн сая таван зуун мянган/ төгрөг</b> <b>Багц №1 : Хөдөлмөр хамгааллын хувцас 95,931,000.00 /Ерэн таван сая есөн зуун гучин нэгэн мянган/ төгрөг</b> <b>Багц №2 : Багаж хэрэгсэл 8,569,000.00 /Найман сая таван зуун жаран есөн мянган/ төгрөг</b>
<b>Б. АГУУЛГА</b>	
ТШЗ 8.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:

	<p>Хүлээн авагчийн нэр: “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК</p> <p>Хаяг: Чингэлтэй дүүрэг, VI хороо, 53/3 ТОСК-ийн байр</p> <p>Утасны дугаар: 72887788</p> <p>Цахим шуудангийн хаяг: <a href="mailto:info@tosk.gov.mn">info@tosk.gov.mn</a></p> <p><b>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалаар батлагдсан Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 24.4-т “хуулийн 19.1-д заасны дагуу тодруулга авах хүсэлт сонирхогч этгээдээс гаргасан бол түүний нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр цахим систем дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлж, тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлтийг захиалагчаар батлуулж, нийтлэх” гэж заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.</b></p>
ТШЗ 11.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үзүү”
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
ТШЗ 12.2	Зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардаадах баримт бичиг: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем-ээр дамжуулан шалгана.</li> <li>- Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиололд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>- Татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр Татварын өөрнхий газар болон нийгмийн даатгалын цахим мэдээллийн сангаас шалгана.</li> <li>- Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</li> </ul>

	<p>Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлттээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэг сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
<b>ТШЗ 17.4</b>	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: “Үгүй”
<b>ТШЗ 17.6</b>	Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: “Үгүй”
<b>ТШЗ 18.1</b>	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардахгүй”</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: <b>“Шаардлагатай” 2023, 2024 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөөт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актыг 1 удаа ирүүлнэ.</b></p> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудын борлуулалтын орлогын нийлбэр нь тухайн багцын төсөөт өртгийн үнийн дүngийн 70 хувиас багагүй байх.</b></p> <p><b>Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөөт өртгийн 70 хувиас дээш ашигтай ажилласан байх.</b></p> <p><b>Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшиг өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна.</b></p> <p>-Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшиг өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл, “Хэвийн” бус байгаа тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: “Шаардлагатай”</p> <p><b>2023, 2024 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөөт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актыг 1 удаа ирүүлнэ.</b></p>
<b>ТШЗ 18.2</b>	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардахгүй”
<b>ТШЗ 19.1</b>	Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”

	<p><b>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2023, 2024 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.ebalance.mof.gov.mn">www.ebalance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</b></p> <p><b>-Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг Сангийн яамны санхүүгийн тайлангийн <a href="http://www.ebalance.mof.gov.mn">www.ebalance.mof.gov.mn</a> мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана.</b></p> <p><b>-Санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.</b></p>									
ТШЗ 20.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b><u>“Тийм”</u></b></p> <p><b>-Байгууллагын талаарх танилцуулга ирүүлнэ.</b></p> <p><b>-Үнийн санал маягтын дагуу ирүүлнэ.</b></p> <p><b>-Ижил төстэй гэрээний туршилага: “Шаардана”</b></p> <p><b>2023, 2024 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөөт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа 1 удаа нийлүүлсэн, мэдээллийг нэгтгэн ирүүлэх ба гэрээ, гэрээ дүгнэсэн акт, захиалагчийн тодорхойлолтын хамт V бүлгийн Маягт 2, Маягт 4-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл ирүүлнэ.</b></p> <p><b>-Барааны үнийн задаргаа, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</b></p> <p><b>-Захиалагчид нийлүүлэх бараа материал нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, шинэ, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх бөгөөд бараа бүтээгдэхүүнд гологдол гарсан тухай бүрд яаралтай шинээр сольж өгөх тухай албан мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ.</b></p> <p><b>-Захилагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дараах хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:</b></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center; padding: 5px;">Захилагчийн шаардсан техникийн тодорхойлолт</th> <th style="text-align: center; padding: 5px;">Нийлүүлэгчийн санал болгож буй техникийн тодорхойлолт</th> <th style="text-align: center; padding: 5px;">Фото зураг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> <td style="text-align: center; padding: 5px;">.....</td> </tr> </tbody> </table> <p>Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардахгүй”</b></p>	Захилагчийн шаардсан техникийн тодорхойлолт	Нийлүүлэгчийн санал болгож буй техникийн тодорхойлолт	Фото зураг	.....	.....	.....	.....	.....	.....
Захилагчийн шаардсан техникийн тодорхойлолт	Нийлүүлэгчийн санал болгож буй техникийн тодорхойлолт	Фото зураг								
.....	.....	.....								
.....	.....	.....								
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>									

<b>ТШЗ 21.6</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: <b>“Тийм” Incoterms 2020, DDP, Чингэлтэй дүүрэг, VI хороо, 53/3 ТОСК-ийн байр</b>
<b>ТШЗ 24.1</b>	Тендерийн баталгааны дүн: <b>“Үгүй”</b>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.5.</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>ТБОНӨХБАУХАТухай хуулийн 7 дугаар зүйлд заасан оролцогчийн ерөнхий шаардлагууд</b></li> <li><b>Тендерт шалгаруулалтын баримт бичигт тусгасан маягтын дагуу илгээсэн мэдэгдэл</b></li> <li><b>Тендер шалгаруулалтын баримт бичигт ил болгохоор заасан бусад баримт бичиг</b></li> </ol>
<b>ТШЗ 26.1.</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2025 оны 5 сарын 29-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<b>ТШЗ 26.2.</b>	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: <b>2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 30 минут</b></p> <p>Тендер нээх газрын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, VI хороо Их тойруу 53/3 ТОСК-ийн байр 3 давхар 310 тоот</b></p>
<b>Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ</b>	
<b>ТШЗ 29.2.</b>	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <b>“Үгүй”</b>
<b>ТШЗ 31.1.</b>	<p>Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: <b>“Тийм”</b></p> <p>Нийлүүлэх бараа нь Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөн батлагдсан <b>“Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”</b>-д орсон бараа байх бөгөөд Стандарт, хэмжил зүйн газраас олгосон тохирлын гэрчилгээг ирүүлнэ.</p> <p>/Тус гэрчилгээ нь тендер хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна/.</p>
<b>ТШЗ 32.1</b>	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>“Ашиглахгүй”</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшигүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бух бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

## *Шалгалт, туршилт*

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

*Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]*

## Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Барааны нэр:** .....

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b> <i>(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)</i>	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b> <i>(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)</i>	<b>Тайлбар</b> <i>(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)</i>
2			
3			
...			

*[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]*

**ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ**

<b>№</b>	<b>Хамгаалах хэрэглэлийн нэр</b>	<b>Тоо хэмжээ</b>	<b>Хэмжих нэгж</b>
<b>Багц №1. Нэг бурийн хамгаалах хэрэгсэл</b>			
1	Зуны хос	38	ширхэг
2	Зуны ээлжийн өмд	38	ширхэг
3	Бүс	38	ширхэг
4	Нимгэн хантааз /зуны/	38	ширхэг
5	Зуны поло подволк	38	ширхэг
6	Нимгэн подволк	38	ширхэг
7	Хавар намрын хос	38	ширхэг
8	Флийз цамц	38	ширхэг
9	Өвлийн хос хувцас	38	ширхэг
10	Борооны куртиг	38	ширхэг
11	Зузаан хантааз	38	ширхэг
12	Касканд өмсөх малгай	37	ширхэг
13	Хүзүүвч	38	ширхэг
14	Каск /дуулга/	14	ширхэг
15	Ажлын бээлий /өвөл/	115	ширхэг
16	Ажлын бээлий /зун/	168	ширхэг
17	Усны гутал	25	ширхэг
18	Өндрийн бүс /цээж бүс/	30	ширхэг
19	Ажлын хамгаалалттай гутал/зун/	38	ширхэг
20	Ажлын хамгаалалттай гутал/өвөл/	38	ширхэг
21	Өвдгөвч /Өвдөгний хамгаалалт/	30	ширхэг
22	Хамгаалалтын нүдний шил	38	ширхэг
23	Багажны цүнх	30	ширхэг
24	Өмдний шуумаг	76	ширхэг
25	Цахилгаанчны тусгай гутал	1	ширхэг
26	Цахилгаанчны бээлий 400 вольт	10	ширхэг
27	Цахилгаанчны хувцас ARC FLASH	1	ширхэг
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1107</b>	
<b>Багц №2. Хөдөлмөр хамгааллын багаж, хэрэгсэл</b>			
1	Индектор	2	ширхэг
2	Ампер клиш	1	ширхэг
3	TAJIMA метр 10м	20	ширхэг
4	Рульт метр 50м, 100м	5	ширхэг
5	Гар шийдэн	25	ширхэг
6	Духны гэрэл	25	ширхэг
7	Сүлжээний тест	1	ширхэг
8	Лазер тэгш ус	2	ширхэг
9	Лазер метр	2	ширхэг
10	Тажима 40см тэгш ус	2	ширхэг
11	Булан чиг	5	ширхэг
12	Штангенциркуль	1	ширхэг
13	Рек	2	ширхэг
14	Агаарын хурд хэмжигч /уртасгагч	1	ширхэг

	төмөртэй/		
15	Дулааны мэдрэгч камер	1	ширхэг
16	Драгер /согтуурал хэмжигч/	1	ширхэг
17	Анхны тусламжийн иж бүрэн цүнх	1	ширхэг
	<b>БАГЦ №2 НИЙТ ДҮН</b>	<b>97</b>	

## **ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

- ✓ Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн тодорхойлолтод дурдсан бараанаас 1 ширхгийг өгнө.
- ✓ Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид анх ирүүлсэн загварын хувцаснаас материал, чанар (гараар мэдрэхэд ялгаагүй), хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрүүгүй байна.  
Ялгаа гарсан тохиолдолд захиалагч ирүүлсэн хувцсыг бүгдийг гүйцэтгэгчид бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаардлага хангасан хувцсаар солиулна.
- ✓ Хувцас хэрэгсэлд орсон материал нь хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлчлэлгүй, биеийн хөлстэй урвалд орох чанаргүй, мөн шатахад барьж наалддаггүй байх ба зориулалтын хувцасны материал байна.
- ✓ Материал нь мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт), шинжилгээний бичиг зэрэг дагалдах баримт бичигтэй байна.
- ✓ Хөлөргөж чийг татахаас сэргийлсэн агаар сэлгэлт сайтай, амьсгалдаг материал эсвэл технологи ашигласан байна.
- ✓ Ажлын хувцасны бүх оёдлыг 1 см-т 4-5, дотор холбох, хавсарсан оёдлыг 1 см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын 100% даавуун утсаар оёно. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийж өгсөн байна.
- ✓ Ажлын хувцас бүр гэрэл ойлгогч цацууллагчтай байх ба оёсон байна.
- ✓ Угаалгын градус  $+30^{\circ}\text{C}$ -аас  $+60^{\circ}\text{C}$ -д угааж,  $+60^{\circ}\text{C}$ -аас  $+71^{\circ}\text{C}$ -д хатаахад өнгө болон дотор материалын агшилт суналт доорх шаардлагыг хангасан байна.
- ✓ Угаалга цэвэрлэгээний дараа агшиж (агшилт суналт нь анхны хэмжээний 5%-иас ихгүй) сунахгүй буюу өмсгөлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байна.  
(Угаалтаар агшиж, сунасан тохиолдолд ажлын хувцсыг бүгдийг солино).
- ✓ Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, арчилгааны заавар болон бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрд оёж тогтоосон байна.
- ✓ Ажлын хувцас нь эрэгтэй, эмэгтэй загвартай байна. Биеийн анатоми хэлбэрт тохирсон байна.  
Эрэгтэй 48, 50, 52, 54, 56, 58, 60, 62, 64 ; Эмэгтэй 42, 44, 46, 48, 50, 52, 54 гэсэн хэмжээтэй байх ба том размерыг захиалгаар хэмжээс авч үйлдвэрлэнэ.  
Ажлын хувцас тус бүр дугаарлалын тэмдэглэгээ бүхий давтагдахгүй хувийн дугаартай байна.
- ✓ Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
- ✓ Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно.
- ✓ EN 397:2012 “Хамгаалалтын малгай”-ны стандарт  
MNS 4931:2000 “Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага” хангасан байна.
- ✓ MNS ISO 13688:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас-Ерөнхий шаардлага” стандарт, MNS 4931:2000 “Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих шаардлага хангасан байна.
- ✓ MNS 5622:2011 Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага, EN 166:2002 “Хамгаалалтын нүдний шил”-ний стандарт хангасан байна.
- ✓ EN 342:2017 “Хүйтэн нөхцөлд өмсөх ажлын хувцас”-ны стандарт, MNS 5623:2006 Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал стандартуудыг хангасан байна.
- ✓ EN 361:2002 “Өндрийн бүс” стандарт, ISO 20345:2011 “Ажлын хамгаалалттай гутал”-ны стандартыг хангасан байна.
- ✓ MNS 5389:2004 “Толгой хамгаалах хэрэгсэл-Нүд хамгаалах хэрэгсэл-Нүдний шил. Техникийн ерөнхий шаардлага” стандарт хангасан байна.
- ✓ MNS 5624:2006 “Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч” стандартыг хангасан байна.

**Тендерт оролцогч нь гэрээ байгуулагдсан даруй 42, 44, 52, 54 размерынхаас 1, 1 ширхэг загвар ирүүлж өмсгөлийг тааруулж үзэх боломжтой байна.  
Энэхүү хэмжээгээр хувцасны размер хэмжээг тодорхойлсны үндсэн дээр захиалгыг гүйцэтгэнэ.**

**Даавууны материалын өнгө нь дараах өнгөний кодны аль нэг байх.**

LAB	(37,6,20,0)	(52,3,2,0)
HEX	#4a4a4a5	#5233333

LAB	(38.66, 0, 0)	(63.22, 0, 0)
HEX	#5b5b5b	#999999

**БАГЦ – 1**


Барааны нэр:	Зуны хос
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна..
Үзүүлэлт, шаардлагууд	Хувцас бүрт цацуулагч буюу гэрэл ойлгогч хийсэн байна. Гэрэл ойлгогч нь энгэр хэсэгт 3 см, ар нуруунд 5 см өргөнтэй хөндлөн байна. Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах үүднээс хүрэмний ханцуйн мөрний залгаас хэсэгт ар талын эсгүүрийн өргөн нь урд талын эсгүүрээс 2-3 см урт байна. Хүрэмд хөдөлгөөн хийхэд саад болохооргүй шингээлтийг хийж өгсөн байна.

Ажлын хувцас	Хүрэмний баруун энгэрт станц тогтоох 2x5 см хэмжээтэй тогтоогч оёно.  Хүрэм нь ар нуруу, цээж, суганы хэсэгт хөлрөхөөс хамгаалсан торон (торон дотор нь өмсөж, тайлахад саад болохооргүй, сунахааргүй) дотортой байна.  Хүрэм нь салхи орохоос хамгаалсан босоо захтай байна.  Ханцуйны хагалбар 18-20 см байх бөгөөд хагалбар нь далд буюу хоорондоо битүү холбоостой байна. Хүрмийн урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна. Хүрэмний энгэрийн дээд талд 2 талдаа кноп бүхий тагтай ил халаастай байна. Зүүн энгэрийн халаасанд бал, үзгийн нэмэлт таславч оёж өгсөн байна. Өмдний ташаа хэсэгт далд халаастай, гуяны гадна талд хөндийрүүлэгчтэй, зангуу бүхий тагтай 2 ил халаастай байна. Хүрмийн энгэрийн хоёр талын доод хэсэгт ил халаастай байна. Халаасанд гар хийх хэсэг нь ташуу, бээлийтэй гар орохоор зайдай байна.
--------------	--

	Хүрэмний баруун энгэрт станц тогтоох 2x5 см хэмжээтэй тогтоогч оёно.
	Хүрэм, өмдний хөндийрүүлэгчтэй халааснуудын дээд үзүүрийн ирмэгийг гадагш болохооргүйгээр их биед даруулж оёно.
	Хүрэм нь цахилгаантай задгай энгэртэй, цахилгаанаа дарсан кноп (сайн чанарын) бүхий хаалттай, цахилгаан бат бөх байх ба угаалгад тэсвэртэй материалыар хийгдсэн байна.
	Арын суудал, өвдөг хэсэгт элэгдлээс хамгаалсан давхарлагaa ширээстэй хийгдсэн байна.
